

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН
ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН
ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЯВУУЛСАН ТАЛААРХ
НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 06 дугаар
сарын 20-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэн шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Нийгмийн бодлогын байнгын хороо 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу зүйл бүрээр хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан саналуудыг нэг бүрчлэн хэлэлцэж, дараах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулж байна. Үүнд:

Нэг.Хөдөлмөрийн хүнд нөхцөлөөр тэтгэвэрт гарч буй даатгуулагчийн нөхцөлийг хэвээр үлдээхээр, хөдөлмөрийн хортой, халуун нөхцөл болон газрын дор ажиллаж байгаа даатгуулагчийн тэтгэвэрт гарах насыг нэмэгдүүлэхгүй байхаар;

Хоёр.2018 оноос дараалсан зургаа болон долоон жилийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр бодуулсан тэтгэвэр авагчийн тэтгэврийг хууль хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан нэг удаа шинэчлэн тогтоохоор;

Гурав.“Тэтгэврийн тогтолцоо” гэсэн бүлгийг “Тэтгэврийн төрөл” болгон өөрчлөн найрууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг хуулийн төсөл нь Улсын Их Хурлаас баталсан “Тэтгэврийн талаар төрөөс баримтлах бодлого”-ын баримт бичигтэй нийцэж байгаа эсэх талаар, төсөл батлагдсанаар улсын төсвийн ачаалал болон нийгмийн даатгалын сангийн зардал хэрхэн нэмэгдэх талаар, нас барсан тэтгэвэр авагчийн нөхөр эсхүл эхнэрийн тэтгэврийг 20 хувиар нэмэгдүүлэхэд шаардагдах санхүүжилтийн талаар, мөн 10 ба түүнээс дээш жил хамтран

амьдарсан гэсэн шалгуурыг хэрхэн тооцож гаргасан талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэг хуулийн төсөлд малчдын нийгмийн даатгалын шимтгэлийн 50 хувийг төр хариуцсанаар улсын төсөвт үүсэх ачааллын талаар болон малчдад зориулсан бусад тусгай зохицуулалтын талаар, хүнд нөхцөлд ажилладаг уурын зуухны галч нарыг нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгох боломжийн талаар асуулт асууж, хариулт авлаа.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилоос хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Монгол Улсын Шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг буцаах зарчмын зөрүүтэй санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг буцаах зарчмын зөрүүтэй саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Мөн Улсын Их Хурлын гишүүн С.Чинзоригоос хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалттай холбогдуулан нас барсан тэтгэвэр авагчийн 10 ба түүнээс дээш жил хамтран амьдарсан нөхөр, эсхүл эхнэрийн тэтгэврийг 20 хувиар нэмэгдүүлж олгоно гэсний 10 жил гэсэн шалгуурыг нэмэгдүүлэх талаар гаргасан зарчмын зөрүүтэй 1 саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Статистикийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг

дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өршөөл үзүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

НИЙГМИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

П.АНУЖИН

